



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/178

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажилд арчилгаа хамгаалалт хийх (Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Сэлэнгэ, Орхон) ажлын Багц №03 Орхон сумын “Орхон голын арал” сумын төвөөс баруун урд 300м газарт 3 га талбай, Сэлэнгэ сумын “Таримал” төвөөс 4-5 км газарт 3 га талбайд нийт 6 га талбайд ойн зурвасын арчилгаа хамгаалалтын ажил хийх” гүйцэтгэгчээр шалгарсан “Хөвөнтөн ой” ХХК-тай 24,000,000 (хорин дөрвөн сая) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Хөвөнтөн ой” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ч.Оюун)-д даалгасугай.

3. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010240

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 10-ны/ний өдрийн
А/А.32 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	2026.04.20-2026.10.25	А.Гантөмөр
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана	А.Гантөмөр Б.Очирсүрэн
3	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Очирсүрэн

--o00o--